



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 11 сарын 14 өдөр


Дугаар А/542

Булган

“Тогтвортой хөгжил-түншлэл” хамтын
ажиллагааны зөвлөл байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4. д, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6, 5.1.7, Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ын 2.2.1, 2.2.3, Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны II/05 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.5.2, 1.5.3, 2.2.3, 2.2.5, 2.3.1, 2.3.2, 2.5.1, 2.5.2, мөн хурлын 2017 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” дэд хөтөлбөрийн 5.2, 2019 оны XI/03 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ хөдөө-Булган” дэд хөтөлбөрийн 4, 5, 6, 2019 оны XIII/02 дугаар тогтоолоор батлагдсан “Булган аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөө”-ний 4.1, 4.2, 4.3, 4.4, 4.5, 5.1 дэх зорилтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутагт бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд төр, иргэний нийгмийн байгууллага, жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн тэгш оролцоог хангах зорилго бүхий “Тогтвортой хөгжил-түншлэлийн зөвлөл”-ийг байгуулж, аймгийн Засаг даргын дэргэд ажиллуулсугай.
2. “Тогтвортой хөгжил-түншлэлийн зөвлөл”-д оролцогч талуудаас төлөөлөн ажиллах бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
3. Зөвлөлийн ажиллах журмын төслийг 2019 оны 11 дүгээр сарын 20-ны дотор багтаан Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулахыг ажлыг хэсэг /Ц.Бат-Өлзий/-т даалгасугай.



З.БАТЗОРИГ

Аймгийн Засаг даргын 2019 оны 11
дүгээр сарын 14-ний өдрийн 1/572 дугаар
захирамжийн хавсралт

“Тогтвортой хөгжил- түншлэлийн зөвлөл”-ийн
бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга: - Ц.Бат-Өлзий /аймгийн Засаг даргын орлогч/

Гишүүд:

- Д.Мэндсайхан /аймгийн ИТХ-ын Төлөөлөгч, Ажил олгогч эздийн холбооны тэргүүн, зөвшилцсөнөөр/
- Б.Оюунбат /аймгийн ИТХ-ын Төлөөлөгч, Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн захирал, зөвшилцсөнөөр/
- Д.Буманбаяр /Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга/
- Ч.Амгалан /Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга/
- Ч.Лхагва /Хүнсчдийн холбооны тэргүүн/
- Д.Дарьсүрэн /Урлаг дизайны академийн тэргүүн, Боловсрол судлалын доктор/
- Д.Эрдэнэчимэг /“Үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээний нэгдсэн холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал/
- Ч.Жаргалсайхан /“Хатан Мээж хайрхан” ХХК -ийн захирал/
- Н.Мөнх-Эрдэнэ “Тотал сэлес” ХХК-ийн захирал/
- Б.Баттулга /“Дээж тариа трейд” ХХК-ийн захирал/
- Б.Мөнхбаатар /“Сайхан монгол” ТВ-ийн захирал/

Нарийн бичгийн дарга: Ч.Оюун-Эрдэнэчимэг /ХОХБТХ-ийн Үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлалын салбарын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн/